



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 55,
Утас: 262449, 266246 Факс: (976-11) 32 52 34
И-мэйл: info@sport.gov.mn

2024.01.11 № 1/34

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА НАРТ

Албан тушаалын жишиг
тодорхойлолт хүргүүлэх тухай


Биеийн тамир, спортын газрын бүтцэд шаардлагатай төрийн захиргааны гүйцэтгэх 5 албан тушаалын жишиг тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 529 дүгээр “Зөвшөөрөл олгох тухай” тогтоолын 2, 3, 4, 5, 6 дугаар хавсралтаар батлах зөвшөөрөл олгосон.

Иймд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий этгээд шийдвэр гаргаж, албан тушаал тус бүрээр батална” гэж заасны дагуу аймгийн Биеийн тамир, спортын газрын Биеийн тамирын хэлтсийн дарга, Спортын хэлтсийн дарга, Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн цахим сан, статистик хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг тус тус батлан тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтыг аймгийн Салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулан, сул орон тоог хууль, журмын хүрээнд нөхнө үү.

Хавсралт *31* хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

142420055